



**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

С.Зоригийн гудамж 2, 1 дүгээр хороо
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: (976) 7711 1027, Цахим шуудан: info@fchm.edu.mn

2026.04.01 № 1/672

танай _____-ны № _____-т

Үнийн санал авах тухай

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Өндөр өртөгт тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай эмнэлгийн хэрэгсэлд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасны дагуу үнийн санал ирүүлнэ үү.

Үнийн саналыг 2026 оны 04 дүгээр сарын 03-ны 12 цаг хүртэл хүлээн авна.

Мэйл хаяг: procurement@fchm.edu.mn

Хаяг: УНТЭ-ийн 1 давхар 103 тоот

Хавсралт 1 хуудастай.


ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



П.АНХТУЯА

1422610'9

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын 2026 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн 11672 дугаар албан бичгийн хавсралт



Нэн шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн жагсаалт

№	Эмнэлгийн хэрэгсэл, хиймэл цорго, протез, ортопедийн хэрэгслийн нэршил	Хэмжээ	Техникийн тодорхойлолт	Тоо ширхэг
1	Тархины судасны микрокатетер	Neurovascular microcatheter	Тархины судасны эмчилгээнд зориулагдсан, тархины судасны бүх төрлийн стент (өөрөө тэлэгч, урсгал өөрчлөгч стент гэх мэт)-д тохирох, үзүүр нь шулуун, хэлбэрийг өөрчилж болохуйц зөөлөн, 2 рентген маркертай, нийт уртын хэмжээ 135-160см хүртэл, эхлэх хэсгийн гадна диаметр OD 2.2/1.9F-2.8/2.8F илүүгүй, төгсгөл хэсгийн дотоод диаметр ID 0.0165" - 0.027" хэмжээтэй байх;	1
2	Тархины судасны нарийн диаметртай бичил ороомог, салгагчийн хамт	Neurovascular detachable microcoils	Нэг удаагийн механик салгагчтай болон шаардлагатай үед нугалж салгах боломжтой байх, тархины судасны бичил ороомог: хүний биед харшил өгдөггүй, халууруулах үйлчилгээгүй, эд гэмтээхгүй зөөлөн бүтэцтэй, хоорондоо холбоотой ороомог болон түлхэгч биеэс тогтсон, ороомог утасны диаметр 0.010- 0.012", ороомог утасны урт 1-30см, 3D хэлбэртэй (Framing, Filling, Finishing зориулалттай),	1
3	Гавлын гаднах нарийн судасны хатуу баллон	Neurovascular non complian PTA balloon	Жигд тэлэгдэх, (NC - non compliant balloon catheter) өндөр даралтын тэлэгч ашигладаг катетер, тэлэгдэх дээд хэмжээ 18 atm-ээс доошгүй, Lesion empty profile болон Lowest crossing profile (нарийсалтай судсанд нэвтрэх хэмжээ) нь 0.016 inch ~0.017 ихгүй судсанд нэвтрэх, 2 маркертай, 0.014" инчийн чиглүүлэгч ашиглах боломжтой байх, Хэмжээс: 1.0мм ~ 6.0мм диаметр х 6мм ~ 10 мм дүйцэхүйц техникийн үзүүлэлттэй байх.	1

----- ооОООоо -----